



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/2024

Булган сум

Сэтгүүлчид ба мал аж ахуй, байгаль орчин зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 62 дугаар “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарын байгалийн давагдашгүй хүчин зүйлийг эрсдэл багатай даван туулахад бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, малчдыг мэдлэг мэдээллээр хангах, малчдын сайн туршлагыг олон нийтэд түгээх зорилгоор “Сэтгүүлчид ба мал аж ахуй, байгаль орчин” зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 18-19-ний өдөр зохион байгуулсугай.

2. “Сэтгүүлчид ба мал аж ахуй, байгаль орчин” зөвлөгөөнийг хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Зөвлөгөөн зохион байгуулах зардлыг 2 дугаар хавсралтаар баталж, шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас, 7,357,000 (долоон сая гурван зуун тавин долоон мянга) төгрөгийг “Бэлчээрийн менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас, Сэтгүүлчидтэй холбогдох зардлыг 3 дугаар хавсралтаар баталж, шаардагдах 31,400,000 (гучин нэгэн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Нийгмийн бодлогын хэлтсийн Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4. Дээрх зөвлөгөөнийг бэлтгэл сайтай зохион байгуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010326

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 19-ний өдрийн А.2.4.4 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



“СЭТГҮҮЛЧИД БА МАЛ АЖ АХУЙ БА БАЙГАЛЬ ОРЧИН” ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

Д/д	Сэдэв	Цаг	Хариуцах хүн
1	2	3	4
2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр			
1	Чиглүүлэгч хөтөлбөр танилцуулах	10:00-10:05	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан
2	Хэлэлцүүлгийг нээж үг хэлэх	10:05-10:10	Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ
3	Мэндчилгээ дэвшүүлэх	10:10-10:15	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Эрдэнэбат
4	Илтгэл: Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал	10:15-10:30	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан
5	Илтгэл: Мал аж ахуйн эрхлэхэд малчдын боломж, давуу тал, туршлага	10:30-10:50	Хангал сумын малчин Х.Эрдэнэбулган
6	Илтгэл: Хөрсгүй тариалалт, технологи	10:50-11:10	Хангал сумын малчин С.Саранцэцэг
7	Илтгэл: Монгол улсын мал аж ахуйн ирээдүй болон цөлжилтөөс сэргийлэх нь	11:10-12:40	WANNABE группийн ерөнхийлөгч Жон Ёнг Чол , Сөүл их сургуулийн профессор Чүэ Хунг Рим
8	Малын гаралтай био массын нөөцөөр био нүүрс үйлдвэрлэж, хүлэмжийн хийг бууруулах	12:40-13:00	“Хөдөө аж ахуйн инновацын нэгдэл” ТББ-ийн доктор Д.Баатархүү
9	Өдрийн хоол	13:00-14:00	
10	Илтгэл: Тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх боломжууд	14:00-14:20	Хөдөө аж ахуйн их сургуулийн МАА Биотехнологийн сургуулийн захирал Д.Гүрбазар
11		14:20-14:30	Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч Ө.Отгонбаатар
12	Илтгэл: Мал эмнэлгийн үйлчилгээ	14:30-14:45	Мал эмнэлгийн газрын дарга Г.Одсүрэн
13	Илтгэл: Мал аж ахуйн салбарын цаг уурын судалгаа	14:45-15:05	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер Э.Сарантуяа
14	Илтгэл: Нэг жуулчинд-Нэг хонь хөтөлбөрийн тухай	15:05-15:20	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга А.Гантөмөр
15	Танилцуулга: И-монголиа үйлчилгээний тухай	15:20-15:30	Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн ахлах ажилтан М.Эрдэнэбат
16	Танилцуулга: Малын индексжүүлсэн даатгалын тухай	15:30-15:40	МИГ даатгал ХХК-ийн Булган аймаг дахь салбар
17	Асуулт, хариулт	15:40-16:00	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан
18	Урлагийн номер	16:00-16:25	Хөгжимт жүжгийн театр
19	Хаалтын үйл ажиллагаа	16:25-16:30	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр			
1	Бүртгэл	09:00-09:30	
2	Зөвлөгөөний нээлт	09:30-09:40	Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ
3	Төрийн дуулал эгшиглэнэ	09:40-09:43	

4	Мэндчилгээ дэвшүүлэх	09:43-09:50	Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч Ө.Отгонбаатар
5	Мэндчилгээ дэвшүүлэх	09:50-10:00	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Эрдэнэбат
6	МСНЭ-ийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн танилцуулга	10:00-10:20	
7	Мэндчилгээ дэвшүүлэх	10:20-10:25	МСНЭ-ийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн Ж.Халиунаа
8	Урлагийн номер	10:25-10:30	2-р сургуулийн сурагчид
9	Булган аймгийн танилцуулга видео	10:30-10:40	
10	"Аймгийн нийгэм, эдийн засгийн онцлог үзүүлэлт	10:40-11:00	Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ
11	Асуулт Хариулт	11:00-11:20	
12	Бага үдийн цай	11:20-11:40	
13	Төсөл хөтөлбөр хэрхэн бичих вэ?	11:40-12:40	Номадик контент ХХК үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Г.Гантуяа
14	Асуулт Хариулт	12:40-13:00	
15	Өдрийн хоол	13:00-14:00	
16	Сонгуулийн ерөнхий хорооноос мэдээлэл өгөх	14:10-14:40	
17	Орон нутгийн хэвлэл мэдээллийн чиг хандлага, анхаарах асуудал хэлэлцүүлэг	14:40-16:30	Чиглүүлэгч: МСНЭ-ийн гүйцэтгэх захирал Б.Ууганбаяр Орон нутаг хариуцсан дэд Ерөнхийлөгч Д.Батчимэг МСНЭ-ийн Булган аймгийн салбар зөвлөлийн тэргүүн Ж.Халиунаа
18	Хаалтын үйл ажиллагаа	16:30	

Аймгийн Засаг дарлын 2024 оны
01 дүгээр сарын 15 ний өдрийн 1/2024 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

"СЭТГҮҮЛЧИД БА МАЛ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН" ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ төг
1	2	3	4	5	6
1.Өдрийн хоол					
1	Хоол	хүн	200	19,500	3,900,000
2	Цай	хүн	200	500	100,000
	Дүн				4,000,000
2.Хэвлэлийн зардал					
1	Хэлэлцүүлгийн эх бэлтгэл	ш	10	-	300,000
	Дүн				300,000
3.Урилгаар оролцогчдын зардал (Дотоод)					
1	Илтгэгч	цаг	5	300,000	1,500,000
2	Ирэх, очих зардал	-	5	66,000	330,000
3	Буудал	хоног	5	100,000	500,000
	Дүн				2,330,000
4.Урилгаар оролцогчдын зардал (Гадаад)					
1	Буудлын зардал (2 хоног)	өрөө	4	160,000	1,280,000
2		өрөө	10	130,000	2,600,000
3	Хүлээн авалтын зардал	хүн	25		6,847,000
	Дүн				10,727,000
	Бүгд дүн				17,357,000

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 15-ний өдрийн А.Д.М. дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

СЭТГҮҮЛЧДЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Зориулалт	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4
1	Автобус түрээс	2 500 000*2	5,000,000
2	Буудал	65 000*45*2 хоног	5,850,000
		65 000*45*2 хоног	5,850,000
		Дүн	11,700,000
3	Өдрийн хоол	20 000*90*2	3,600,000
		Дүн	3,600,000
4	Оройн хоол	20 000*45*2	3,600,000
		Дүн	3,600,000
5	Форумын цай	5 000*100	500,000
6	Багшийн зардал		7,000,000
Бүгд дүн			31,400,000